



АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Газрын тос, уламжлалт бус газрын тосны  
эрэл, хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө,  
төсөв зохиох заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв зохиох зааврыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан төлөвлөгөө, төсөв зохиох зааврыг олон нийтэд нээлттэй, ил тод сурталчилж хэлтсийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг Газрын тосны хайгуулын хэлтэс (Б.Сүнжидмаа)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Дашпүрэв)-т даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын  
2021 оны 11 дүгээр /дугаар сарын 25-ний/ өдрийн  
А/189 дугаар /дүгээр/ тушаалын нэгдүгээр хавсралт

## ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ ЗОХИОХ ЗААВАР

### Нэг. Ерөнхий зүйл

Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны хайгуулын хэлтэс нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ дор дурдсан шаардлагыг хангасан эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг хүлээн авч, хянуулах, батлуулах ажлыг зохион байгуулна.

1. Аж ахуй нэгж нь эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг боловсруулахдаа энэхүү заавар болон Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүртгэл тооцооны журам”, тус журмыг даган гарсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын тосны бүртгэл тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлал”-ыг тус тус дагаж мөрдөнө.

2. Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг талбай тус бүрээр Албан хэрэг хөтлөлтийн стандарт (MNS 5140:2011)-ын дагуу бичсэн байна.

3. Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг 1 /нэг/ жилийн хугацаатайгаар боловсруулж, монгол хэл дээр 2 (хоёр) хувь үйлдэнэ. Шаардлагатай бол монгол, англи хэл дээр үйлдэж болох бөгөөд зөрүү гарвал Монгол эхийг баримтална.

Хоёр. Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн бичвэр хэсэг

Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв нь Оршил, Ерөнхий бүлэг, Талбайн геологийн тогтцын товч тодорхойлолт, Эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, Төсвийн тооцоо гэсэн үндсэн бүлгүүд, холбогдох хавсралт зургуудаас бүрдэнэ.

**Оршил хэсэгт** Гэрээлэгч болон оператор компанийн ерөнхий мэдээлэл, Засгийн газрын тогтоол, гэрээ байгуулсан өдөр, эрэл, хайгуулын үйл ажиллагааг түр зогсоосон тухай, эрэл, хайгуулын ажлын хэд дэх жилийн төлөвлөгөөг ирүүлж байгаа болон бусад мэдээлэл багтана.

#### 1. Ерөнхий бүлэг

- 1.1. Гэрээт талбайн байршил,
- 1.2. Физик газарзүй
- 1.3. Геологийн судалгааны түүх
- 1.4. Гэрээлэгчийн ажиллах хүч, техник хангамж, туршлагын талаарх мэдээлэл

#### 2. Талбайн геологийн тогтцын товч тодорхойлолт бүлэг

- 2.1. Геологийн тогтоц
- 2.2. Давхаргазүй
- 2.3. Тектоник

### 3. Эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал бүлэг

- 3.1. Бэлтгэл ажил
  - 3.1.1. Төлөвлөгөө, төсөв зохиох
  - 3.1.2. Бусад
- 3.2. Хээрийн судалгаа
  - 3.2.1. Геофизикийн судалгааны ажил
    - 3.2.2.1 Геофизикийн хайгуулын ажлын хэмжээ, байршил, арга, аргачлал, параметрийн сонголт
    - 3.2.2.2 Хайгуулын ажлыг сонгох үндэслэл
  - 3.2.2. Цооногийн геофизикийн судалгаа
    - 3.2.2.1. Каротажийн ажлын арга, аргачлал
    - 3.2.2.2. Техникийн үзүүлэлт
  - 3.2.3. Өрөмдлөгийн ажил
    - 3.2.3.1. Цооногийн төрөл, байршил геологийн даалгавар зорилго
    - 3.2.3.2. Өрмийн аргачлал
    - 3.2.3.3. Өрмийн хийц (тойм байдлаар)
    - 3.2.3.4. Цооногийн гүн, үнэ /өрмийн үнэд ямар ажил багтаж байгаа талаар тусгах/.
  - 3.2.4. Дээжлэлт
  - 3.2.5. Топо, геодезийн ажил
  - 3.2.6. Тээвэр
    - 3.2.6.1. Хүн тээвэр
    - 3.2.6.2. Ачаа тээвэр
  - 3.2.7. Бусад хээрийн судалгаа
- 3.3. Лабораторийн ажил
  - 3.3.1. Лабораторийн шинжилгээний төрөл
  - 3.3.2. Шинжилгээний төрлийг сонгох үндэслэл
  - 3.3.3. Дээжийг хаана ямар улсад шинжлүүлэх талаарх мэдээлэл
- 3.4. Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- 3.5. Суурин боловсруулалт

### 4. Төсвийн тооцооны бүлэгт

Эрэл, хайгуулын ажлын арга, аргачлалын бүлэгт гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын төрөл, хэмжээг үндэслэн нэгжийн өртгийг бодитойгоор тусгаж төсвийн нэгдсэн тооцоог ам.доллараар илэрхийлэн тооцож хавсралт 2 дахь маягт /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар баталсан “газрын тосны бүртгэл тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлал”-ын 4 дүгээр маягт/-ын дагуу нэгтгэсэн байна. Мөн эрэл, хайгуулын гэрээний хавсралт “В” дахь эрэл, хайгуулын ажлын нийт хугацааны хөрөнгө оруулалтын хүснэгтийг хавсаргасан байна.

Гурав. Бусад

**Хавсралт зураг:** Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөвт Геологийн болон төлөвлөлтийн дэвсгэр зураг зүсэлтийн хамт хавсаргана. Зургийн хэмжээ, масштаб баас хамааруулан зургуудыг тусад нь болон нэгтгэсэн байдлаар зохиож болно. Зургийн масштабыг эрэл, хайгуулын ажил гүйцэтгэх талбайн хэмжээ, судалгааны ажлын үе шатнаас хамааруулан оновчтой сонгосон байна. Зургийн өнгө, тэмдэг тэмдэглэгээ, таних тэмдгүүд, зураг зохиосон, хянасан албан тушаалтны нэр, гарын үсгээр баталгаажсан байх

зэрэг геологийн зурагт тавьдаг шаардлагыг хангасан байна. Мөн төлөвлөгөө, төсвийн бичвэрийн хэсэгт шаардлагатай бүдүүвч, зургуудыг оруулж болно.

1. Хурдас чулуулгийн стратиграфийн ангиллын бичлэгийг Монголын литостратиграфийн кодексын дагуу хийсэн байна.

2. Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөвт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил, зарцуулагдах зардлыг тусгасан байна.

3. Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг зохиоход ашигласан тайлан, материалын нэрсийг зохих дарааллын дагуу жагсааж хавсаргана.

4. Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн нүүр хуудсыг Хавсралт 1-ийн дагуу үйлдсэн байна.

5. Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн үнэн зөв, бодит байдлыг гэрээлэгч бүрэн хариуцна.

#### Дөрөв.Төлөвлөгөөг хянах, батлах

1. Эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг Газрын тосны хайгуулын хэлтсийн хариуцсан мэргэжилтэн хүлээн авч Хяналтын хуудас нээн холбогдох мэргэжилтнүүдээр хянуулах ажлыг зохион байгуулна.

2. Аж ахуй нэгжээс ирүүлсэн эрэл, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв нь уг зааврын шаардлагыг хангахгүй бол албан ёсоор тухайн аж ахуй нэгжид буцаана.

3. Төрийн захиргааны байгууллагаас албан ёсоор буцаасан төлөвлөгөө, төсвийг холбогдох тодотгол, нэмэлт, өөрчлөлтийг хийн 15 хоногийн дотор дахин ирүүлнэ.

4. Уг зааврын шаардлагыг хангасан эрлийн ажлын төлөвлөгөө, төсвийг Газрын тосны хайгуулын хэлтсийн дарга, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг Газрын дарга тус тус батална.

БАТЛАВ: АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН  
ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА  
НЭР ..... ГАРЫН ҮСЭГ.....  
20... оны ... сарын ... өдөр

БАТЛАВ: “.....” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
НЭР ..... ГАРЫН ҮСЭГ.....  
20... оны ... сарын ... өдөр

Төлөвлөгөө боловсруулсан:  
Геологич ..... /нэр/

..... АЙМГИЙН ..... СУМЫН НУТАГТ ОРШИХ  
..... ГЭРЭЭТ ТАЛБАЙН ЭРЭЛ/ХАЙГУУЛЫН ТАЛБАЙД  
20... ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ .....-ЫН ЭРЭЛ/ХАЙГУУЛЫН  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ  
Судалгааны үе, шат: Эрэл/Хайгуул

Төлөвлөгөө хүлээн авсан:

АМГТГ-ын Газрын тосны хайгуулын хэлтсийн мэргэжилтэн .....  
20... оны ... сарын ... өдөр

Батлав:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН  
ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА  
НЭР ..... ГАРЫН ҮСЭГ.....  
Огноо:

Батлав:

“.....” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
НЭР ..... ГАРЫН ҮСЭГ.....  
Огноо:

“.....” ХХК-ИЙН ..... ТАЛБАЙН  
..... ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ

	Зардлын ангилал, төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Нэгжийн үнэ /ам.доллар/	Нийт дүн /ам.доллар/
	А	Б	В	Г	Д
<b>I</b>	<b>ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛ</b>				
<b>1</b>	<b>Хайгуулын ажлын зардал</b>				
1.1	.....				
1.1.1	.....				
	Дүн				
1.2	.....				
1.2.1	.....				
	Дүн				
	Хайгуулын ажлын зардлын дүн				
<b>2</b>	<b>Бүтээн байгуулалтын зардал</b>				
2.1	.....				
2.1.1	.....				
	Дүн				
2.2	.....				
2.2.1	.....				
	Дүн				
	Бүтээн байгуулалтын ажлын зардлын дүн				
<b>3</b>	<b>Олборлолтын үйл ажиллагааны зардал</b>				
3.1	.....				
3.1.1	.....				
	Дүн				
3.2	.....				
3.2.1	.....				
	Дүн				
	Олборлолтын үйл ажиллагааны зардлын дүн				
<b>4</b>	<b>Татан буулгалтын ажлын зардал</b>				
4.1	.....				
4.1.1	.....				
	Дүн				
4.2	.....				
4.2.1	.....				
	Дүн				
	Татан буулгалтын ажлын зардлын дүн				
<b>5</b>	<b>Нийт дүн (1+2+3+4)</b>				
<b>6</b>	<b>Захиргааны зардлын дүн .....%</b>				
<b>7</b>	<b>ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН</b>				
<b>II</b>	<b>ӨРТӨГ НӨХӨГДӨХГҮЙ ЗАРДАЛ</b>				
.	.....				
<b>8</b>	<b>Өртөг нөхөгдөхгүй зардлын нийт дүн</b>				
<b>9</b>	<b>НИЙТ ДҮН</b>				

Ашигт малтмал, газрын тосны газрын  
Газрын тосны хайгуулын хэлтсийн дарга  
Нэр ..... Гарын үсэг.....

“.....” ХХК-ийн  
албан тушаал  
Нэр..... Гарын үсэг.....